






НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2021/06



www.ubstat.mn
www.1212.mn
nalaikh@nso.mn
7023-3672

АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2016-2021	2
 ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	3
 ИРГЭНИЙ БҮРТГЭЛ	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ	6
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	7
 ЭРҮҮЛ МЭНД	8
 СОЁЛ УРЛАГ, БИЕИЙН ТАМИР	10
 ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН	11
 НОГООН БАЙГУУЛАМЖ	12
 ГЭМТ ХЭРЭГ	13
 ТӨСӨВ	14
 ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ	15
 АЖ ҮЙЛДВЭР	16
 МАЛ АЖ АХУЙ	18
 ГАЗАР ТАРИАЛАН	19
 ХАРИЛЦАА ХОЛБОО	20
 АЮУЛГҮЙ БАЙДАЛ	20



ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ 2016-2021

Хүснэгт 1. Дүүргийн нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний VI сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2020	2021
Суурин хүн ам, жилийн эцэст	тоо	36 425	36 911	37 608	37 659	38 690	-
Ажилгүйчүүд, сарын эцэст	тоо	747	348	322	315	234	149
Үүнээс: эмэгтэй	тоо	411	178	166	159	96	77
Шинээр төрсөн хүүхэд	тоо	418	385	423	414	433	378
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	373	244	245	230	206	2 641
Бүртгэсэн гэмт хэрэг	тоо	257	178	224	169	162	109
Орон нутгийн төсвийн орлого	сая төгрөг	9 665.4	9 494.6	10 333.8	12 889.9	20 369.6	13 800.1
Орон нутгийн төсвийн зарлага	сая төгрөг	9 405.9	9 031.7	9 655.6	11 597.4	20 208.8	13 800.1

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Дүүргийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2021 оны 6 сард 149, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 85 хүнээр (57%) буурсан ба 51.7 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна.

Бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн 26.2 хувь нь 15-24 насны залуучууд, 41.6 хувь нь 25-34 насныхан, 17.4 хувь нь 35-44 насныхан, 10.0 хувь нь 45-54 насны, 2.7 хувь нь 55-59 насныхан, 2.0 хувь нь 60-с дээш насныхан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 0.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2. Дүүргийн ажилгүйчүүд, насны бүлэг, хүйсээр, жил бүрийн VI сард

Үзүүлэлт	2018		2019		2020		2021	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ажилгүйчүүд	322	166	315	159	234	96	149	77
Насны бүлгээр:								
15-24	57	27	52	29	60	30	39	14
25-34	114	67	92	40	82	34	62	34
35-44	101	48	95	49	51	20	26	15
45-54	36	19	50	30	33	11	15	11
55-59	9	2	20	9	8	1	4	1
60 +	5	3	6	2	-	-	3	2
Үүнээс : Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	5	1	7	4	2	1	4	3

Хүснэгт 3. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, жил бүрийн VI сард

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо				Дунд эзлэх хувь			
	2018 VI	2019 VI	2020 VI	2021 VI	2018 VI	2019 VI	2020 VI	2021 VI
Ажилгүйчүүд, бүгд	322	315	234	149	100.0	100.0	100.0	100.0
Үүнээс:								
Магистр, доктор	2	4	-	-	0.8	1.3	-	-
Дипломын болон бакалавр	75	60	50	32	14.0	19.0	21.4	21.6
Тусгай мэргэжлийн	15	17	4	7	5.2	5.4	1.7	4.7
Техникийн болон мэргэжлийн	32	27	31	15	15.0	8.6	13.2	10.0
Бүрэн дунд	167	162	128	77	56.0	51.4	54.7	51.7
Суурь	26	33	18	14	7.2	10.5	7.7	9.4
Бага боловсрол	5	3	3	2	0.9	0.9	1.3	1.3
Боловсролгүй	-	9	-	2	0.9	2.9	-	1.3

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс



ИРГЭНИЙ БҮРТГЭЛ


2021 оны эхний 6 сард шинээр төрсөн 378 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн авч, нас барсан 68 хүнийг бүртгэлээс хасаж, 75 гэрлэлт, 13 хосын гэр бүл цуцлалтыг тус тус бүртгэсэн байна.

Шинээр мэндэлсэн хүүхдийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 55 хүүхдээр (12.7%), нас баралт өмнөх оны мөн үеэс 56 (45.2%) тус тус буурсан байна. Нийт мэндэлсэн хүүхдийн 57.2 хувь нь хүү, 42.8 хувь нь охин байна. Нийт нас баралтад 61.8 хувь нь эрэгтэй, 38.2 хувь нь эмэгтэй хүн эзлэж байна.

Хүснэгт 4. Төрөлт, нас баралтын бүртгэл, жил бүрийн эхний VI сард:

Үзүүлэлт	2018 I-VI	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI
Төрсөн хүүхэд, бүгд	423	414	433	378
Үүнээс: Эрэгтэй	216	206	212	189
Эмэгтэй	207	208	215	162
Нас баралт, бүгд	124	113	124	68
Үүнээс: Эрэгтэй	87	75	84	42
Эмэгтэй	37	38	40	26

Зураг 1. Хүн амын ердийн цэвэр өсөлт



Хүснэгт 5. Гэрлэлтээ бүртгүүлсэн хүн, насны бүлгээр, жил бүрийн эхний VI сард

Үзүүлэлт	2019 I-VI			2020 I-VI			2021 I-VI		
	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй
Нийт	196	98	98	138	69	69	150	75	75
18-19	-	-	-	2	-	2	1	1	-
20-24	37	15	22	24	11	13	37	13	24
25-29	60	30	30	41	20	21	53	29	24
30-34	47	27	20	39	21	18	43	24	19
35-39	20	10	10	13	7	5	14	7	7
40-44	13	6	7	5	2	3	2	1	1
45-49	10	5	5	10	6	4	-	-	-
50 +	9	5	4	5	2	3	-	-	-

2021 оны эхний 6 сард гэрлэлтээ баталгаажуулсан 75 хос байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 (8.7%) өссөн байна. Хосуудыг насны бүлгээр нь авч үзвэл 0.7% нь 18-19 насны, 24.7% нь 20-24 насны, 35.3% нь 25-29 насны, 28.7% нь 30-34 насны, 9.3% нь 35-39 насны, 1.3% нь 40-44 насныхан байна.

Хүснэгт 6. Гэр бүл цуцлалт, жил бүрийн эхний VI сард

Үзүүлэлт		2018 I-VI	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI
Гэр бүл цуцлалт, бүгд		28	33	16	13
Гэр бүл байсан хугацаагаар (жилээр)	1 хүртэл	-	2	1	-
	1-3	-	-	2	4
	4-6	4	3	-	2
	7-9	5	4	-	2
	10-14	10	18	11	3
	15-19	1	3	2	-
	20 ба түүнээс дээш	8	3	-	2

2021 оны эхний 6 сард нийт 13 хос гэр бүлээ цуцлуулсан байна. Гэр бүл байсан хугацаагаар нь ангилбал, 30.7% нь 1-3 жил, 15.3% нь 4-6 жил, 30.7% нь 7-9 жил, 23.0% нь 10-14 жил, 30.7% нь 20 ба түүнээс дээш жил ханилсан хосууд байна.

Дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн гэр бүл цуцлалтын үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 (18.7%) буурсан байна.

Дүүрэгт 2021 оны эхний 6 сард үрчлэгдсэн нийт 6 хүүхэд байна. Үүнээс 4 (66.7%) эрэгтэй, 2 (33.3%) эмэгтэй хүүхэд байна.

Хүснэгт 7. Үрчлэлтийн үзүүлэлт, жил бүрийн эхний VI сард

Үзүүлэлт	2017 I-VI	2018 I-VI	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI
Үрчлэгдсэн хүүхэд, бүгд	10	1	7	11	6
Үүнээс: насны бүлгээр					-
3 хүртэл	8	-	2	5	4
3-6	1	1	3	2	-
7-9	-	-	-	2	2
10 ба түүнээс дээш	1	-	2	1	1

Эх үүсвэр: Налайх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс



НИЙГМИЙН ДААТГАЛ

2021 оны эхний 6 сард нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 4937.5 сая төгрөгт хүрч, нийгмийн даатгалын санд төвлөрчээ.


Нийгмийн даатгалын сангаас 2021 оны эхний 6 сард 34672 даатгуулагч иргэнд 15210.8 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон байна.

Хүснэгт 8. Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт, жил бүрийн эхний VI сард

Үзүүлэлт	2020 I-VI		2021 I-VI	
	Даатгуу- лагчдын тоо	Олгосон дүн (сая төгрөг)	Даатгуу- лагчдын тоо	Олгосон дүн (сая төгрөг)
Нийт орлого	-	4 279.9	-	4 937.5
Тэтгэврийн даатгалын сан	-	3 411.8	-	4 364.8
Тэтгэмжийн даатгалын сан	-	425.1	-	312.6
ҮОМШӨ-ний даатгалын сан	-	337.8	-	203.6
Ажилгүйдлийн даатгалын сан	-	90.5	-	56.4
Нөхөн шимтгэл	-	14.6	-	-
Нийт зардал	35 166	14 275.9	34 672	15 210.8
Тэтгэврийн даатгалын сан	31 801	12 195.0	31 430	13 094.2
Өндөр насны тэтгэвэр	20 955	8 432.5	21 874	9 094.1
Тахир дутуугийн тэтгэвэр	6 303	1 487.9	4 886	1 562.0
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	1 788	560.6	1 840	597.8
Цэргийн тэтгэвэр	2 755	1 714.0	2 830	1 840.3
ҮОМШӨ-ний даатгалын сан	2 595	1 353.2	2 452	1 309.6
Тахир дутуугийн тэтгэвэр	2 391	1 286.5	2 314	1 252.4
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	144	62.4	138	57.2
Сувилалын зардал	70	4.3	-	-
ҮОМШӨ ХЧТА ¹	-	-	-	-
Тэтгэмжийн даатгалын сан	643	469.8	660	547.7
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	311	37.9	298	46.1
Жирэмсний амралт	221	320.9	269	408.6
Оршуулга	111	111.0	93	93.0
Ажилгүйдлийн даатгалын сан	127	257.9	130	259.2
Ажилгүйдлийн тэтгэмж	127	257.9	130	259.2

¹ Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн чадвараа түр алдсан

Зураг 2. Даатгалын сангийн зарлага



Тэтгэврийн даатгалын сангаас 2021 оны эхний 6 сард 31430 тэтгэвэр авагч иргэдэд 13094.3 сая төгрөг олгосон байна. Олгосон нийт тэтгэврийн 69.0 хувийг өндөр насны, 11.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.7 хувийг тэжээгчээ алдсан, 14.5 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс



НИЙГМИЙН ХАЛАМЖ

2021 оны эхний 6 сард давхардсан тоогоор нийт 10982 иргэнд халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээ үзүүлж, халамжийн сангийн зарцуулалт өссөн дүнгээр 1874.7 сая төгрөгт хүрчээ.

Хүснэгт 9. Нийгмийн халамжийн үйлчилгээний үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний VI сард

Үзүүлэлт	2020		2021		2021% 2020	
	Хүний тоо	Мөнгөн дүн (сая/төг)	Хүний тоо	Мөнгөн дүн (сая/төг)	Мөнгөн дүн (сая/төг)	Өсөлт, бууралт хувь
	VI	I-VI	VI	I-VI	VI	I-VI
Халамжийн орлого, бүгд	-	3 480.6	-	1 874.7	1 605.9	-46.1↓
Зарцуулалт, бүгд	18 022	3 262.5	10 982	1 826.7	1 435.8	-44.0↓
Халамжийн тэтгэвэр	611	1 055.1	841	628.3	426.8	-40.4↓
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	725	352.8	712	373.3	20.5	5.8↑
Ахмад настны хөнгөлөлт	517	160.0	1 626	52.6	107.4	-32.8↓
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд	714	68.3	296	20.7	47.6	-69.7↓

Хүснэгт 9-ын үргэлжлэл

Үзүүлэлт	2020		2021		2021% 2020	
	Хүний тоо	Мөнгөн дүн (сая/төг)	Хүний тоо	Мөнгөн дүн (сая/төг)	Мөнгөн дүн (сая/төг)	Өсөлт, бууралт хувь
	VI	I-VI	VI	I-VI	VI	I-VI
Алдарт эхийн одонгийн тусламж	2 594	349.2	-	-	-	-
Алдар цолтой ахмад настуудад олгосон	13	14.4	-	-	-	-
Хүнс тэжээл хөтөлбөрийн зардал	6 688	631.8	6 868	487.4	144.4	-22.8 ↓
Амьжиргааг дэмжих зөвлөл	1 520	179.7	572	248.8	69.1	38.5 ↑
Насны хишгийн зардал	1 800	283.3	-	-	-	-
Цалинтай ээж хөтөлбөр	2 700	74.2	-	-	-	-
Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	10	12.8	11	13.2	0.4	3.1 ↑
Өрх толгойлсон эцэг эхийн хөтөлбөр	130	80.9	-	-	-	-
Амьжиргааг дэмжих сум хоорондын урамшуулал	-	-	56	2.4	56	2.4 ↑

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс



ЭРҮҮЛ МЭНД

2021 оны эхний 6 сард төрсөн эхийн тоо өмнөх оны мөн үеэс 42 (9.6%), нас баралт 12 (8.7%) тус тус өссөн байна.

Хүснэгт 10. Төрөлт, жил бүрийн эхний VI сард

Үзүүлэлт	2018 I-VI	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI
Амаржсан эхийн тоо, бүгд	430	404	436	478
Амьд төрсөн хүүхэд	436	405	440	485
Амьгүй төрсөн	4	3	2	2
Эхийн эндэгдэл	-	-	1	-
Нас баралт	136	130	138	150
Үүнээс: 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	4	8	4	12
Эмнэлгийн нөхцөлд гарсан нас баралт	7	12	8	23
Гэрийн нөхцөлд гарсан нас баралт	102	87	109	100
Улаанбаатар хотод бүртгэгдсэн нас баралт ²	27	31	21	27

² Дүүргийн харьяат иргэдээс Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлж байгаад гарсан нас баралт

2021 оны эхний 6 сард бүртгэгдсэн нийт нас баралтын 66.7% хувийг гэрийн орчин нөхцөлд гарсан нас баралт эзэлж байгаа бол 18.0 хувийг Улаанбаатар хотод хэвтэн эмчлүүлж байгаад гарсан, 15.3 хувь хувийг дүүргийн эмнэлэгт гарсан нас баралт эзэлж байна.

Хүснэгт 11. Дүүргийн хэмжээнд гарсан халдварт өвчин, жил бүрийн эхний VI сард


Үзүүлэлт	2018 I-VI	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	10 мянган хүн тутам
Нийт халдварт өвчин	245	230	206	2 641	677.8
Халдварт өвчин:	99	81	31	2 510	648.7
Гепатит В вирус	1	1	1	1	0.3
Гепатит С вирус	-	1	1	1	0.3
Гепатит Е вирус	-	1	-	-	-
Менинжет	1	45	1	-	-
Салхин цэцэг	46	3	13	6	1.5
паротит	4	6	1	-	-
Ёлом	1	2	1	1	0.3
дизентери	7	2	3	-	-
Гар, хөл, амны өвчин	14	14	2	-	-
Хоолны хордлого	1	-	-	-	-
Сальмонеллөз	1	-	-	-	-
Энтеровируст халдвар	15	-	-	-	-
Улаан эсэргэнэ	5	5	6	1	0.3
Эритема	2	-	-	-	-
Экзантема сабитум	1	-	-	-	-
Хачигт риккетиз	-	-	2	-	-
Хачигт энцефалит	-	1	-	-	-
Коронавирус	-	-	-	2 500	646.2
Сүрьеэ	31	26	29	30	7.7
Арьс өнгөний өвчин	115	123	146	101	26.1
Тэмбүү	42	30	35	40	10.3
Үүнээс: төрөлхийн	-	-	-	-	-
Заг хүйтэн	23	32	43	35	9.0
Бэлгийн замын мөөгөнцөр	20	24	-	8	-
Мөөгөнцөр	-	-	38	-	-
Трихомониаз	30	37	30	18	4.6

Эрүүл мэндийн үзүүлэлтээр дүүргийн хэмжээнд коронавируст халдвар эхний хагас жилд 2500 бүртгэгдсэн байна. Бусад төрлийн хурц халдварт өвчнөөр 10 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21 (67.7%) хүнээр буурч, арьс өнгөний өвчлөл 101 гарсан нь 45 (30.8%) хүнээр, сүрьеэгээр 30 хүн өвчилсөн нь 1 (3.4%) тохиолдлоор тус тус өссөн байна. Нийт халдварт өвчний гаралт 141 байгаа нь өмнөх оны мөн үеэс 65 (31.5%) буурсан байна.

Хүснэгт 12. Эмнэлгийн үзлэгийн үзүүлэлт, жил бүрийн эхний VI сард


Үзүүлэлт	2018 I-VI	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	Өсөлт, бууралт хувь
Урьдчилан сэргийлэх тарилга	2 859	3 120	3 438	3 278	-4.6↓
Амбулаторын үзлэг	102 846	95 926	95 012	107 884	13.5↑
Ор хоног	27 761	28 913	24 956	20 872	-16.4↓
Эмчийн тоо	75	78	76	84	10.5↑
Сувилагчийн тоо	98	105	108	100	-7.4↓
Орны тоо	227	227	227	227	-

Зураг 3. Эмнэлгийн үзлэгийн үзүүлэлт



Амбулаторийн үзлэгийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12872 (13.5%) өссөн, ор хоног 4084 (16.4%), урьдчилан сэргийлэх тарилга 160 (4.6%) тус тус буурсан байна.

Эх үүсвэр: Эрүүл мэндийн төв



СОЁЛ УРЛАГ

Дүүргийн соёл, урлагийн байгууллага 2021 оны эхний эхний хагас жилд цар тахлын улмаас хөл хорио тогтоосонтой холбогдон ажиллаагүй байна.

Хүснэгт 13. Соёл, урлагийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, 2021 оны эхний VI сард

Ажил үйлчилгээ	Нийт	Үүнээс:					Номын сан (уншигчид)	Музейн ³ үзэгчид
		Урлагийн тоглолт	Хурал цуглаан	Кино үзвэр	Уралдаан тэмцээн	Дугуйлан сургалт		
Бүгд	-	-	-	-	-	-	-	-

Эх үүсвэр: Соёл урлагийн ордон

³ Орон нутаг судлах танхим



ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН

2021 оны эхний 6 сард хот тохижилтын ажил үйлчилгээний нийт орлого 129.4 сая төгрөг болж, орлогын 32.6 хувийг орон сууц, 35.4 хувийг гэр хороолол, 32.0 хувийг аж ахуйн нэгжээс хуримтлуулсан орлого эзэлж, нийтдээ 13.8 мянган тонн хогийг зөөж, тээвэрлэсэн байна.

Хүснэгт 14. Хот тохижилтын үзүүлэлт, жил бүрийн эхний VI сард

Үзүүлэлт	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	Үүнээс:		
				Орон сууцны	Гэр хороолол	ААНБ
Нийт орлого, сая төгрөг	133.3	145.7	129.4	42.2	45.8	41.4
Хог тээвэрлэлт, мянган тонн	26.8	12.2	13.8	4.9	6.0	2.9

Эх үүсвэр: Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар

Хүснэгт 15. Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ, жил бүрийн эхний VI сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I-V	2019 I-V	2020 I-VI	2021 I-VI
Шахсан ус	мянган м ³	473.4	515.8	430.1	453.1
Борлуулсан ус	мянган м ³	200.6	539.7	244.3	692.5
Үүнээс: Хүн амд	мянган м ³	130.3	333.5	159.9	423.3
Аж ахуйн нэгж байгууллагад	мянган м ³	70.3	206.2	84.4	269.2
Татан зайлуулсан бохир	мянган м ³	193.5	387.2	175.2	579.7
Ус борлуулалтын орлого	сая төгрөг	244.9	722.7	361.0	920.1
Сувагжуулалтын орлого	сая төгрөг	172.3	407.2	185.2	468.1
Халаалтын орлого	сая төгрөг	82.6	204.2	132.5	307.1

2021 оны эхний 6 сард дүүргийн хэмжээнд 692.5 мянган м³ ус борлуулснаас, 423.3 мянган м³ (61.1%) усыг хүн амд, 269.2 мян.м³ (38.9%) усыг аж ахуйн нэгж байгууллагад түгээсэн байна.

Эх үүсвэр: Чандмань Налайх ОНӨААТҮГазар



НОГООН БАЙГУУЛАМЖ

Хүснэгт 16. Ногоон байгууламжийн хэмжээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019	2020	2021	Хотын нийтийн эзэмшилд
Шинээр тарьсан нэг наст ургамал	Ширхэг	30 000	32 500	15 000	15 000
Шинээр цэцэрлэгжүүлсэн талбай	Мян.м ²	0.71	0	0.85	0.85
Шинээр зүлэгжүүлсэн талбай	мян.м ²	0.739	9.1	0.4	0.4
Байгуулсан цэцгийн мандал	мян.м ²	279	0.9	0.9	0.9
Нөхөн цэцэрлэгжүүлсэн талбай	м ²	2.7	-	0.31	0.31
Нөхөн зүлэгжүүлсэн талбай	Мян.м ²	10.9	4.6	0.36	0.36
Арчилж тордсон зүлэг	Мян.м ²	11.6	-	21	0.4
Цэцэрлэгжсэн талбай	Мян.м ²	0.7	-	24.6	0.85
Шинээр тарьсан мод	Ширхэг	1 224	114	97	-
Шинээр тарьсан сөөг	Ширхэг	833	4 000	1 565	-
Нөхөн тарьсан мод	Ширхэг	588	-	19	19
Нөхөн тарьсан сөөг	Ширхэг	9 940	-	2 400	2 400
Арчилж тордсон мод	Ширхэг	1 812	-	8 700	-
Сөөг	Ширхэг	9 940	-	28 417	-

2021 оны эхний 6 сард 37.1 мянган мод, сөөг арчилж тордсон байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин өссөн байна.

Эх үүсвэр: Цэцэрлэгжүүлэлтийн алба



ГЭМТ ХЭРЭГ


Дүүрэгт 2021 оны эхний 6 сард 109 гэмт хэрэг гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 53 гэмт хэргээр (32.7%) буурч, гэмт хэргийн илрүүлэлт 40.6 хувьтай байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэгт 89 сэжигтэн яллагдагч холбогдсоныг насны ангиллаар авч үзвэл, 17 хүртэлх насны 2 (2.2%), 18-24 насны 24 (27.0%), 25-29 насны 12 (13.5%), 30-34 насны 17 (19.2%), 35-39 насны 7 (7.9%), 40-44 насны 15 (16.9%), 45-49 насны 5 (5.6%), 50-54 насны 3 (3.3%), 55-59 насны 3 (3.3%), 60-64 насны 1 (1.1%) иргэд байна.

Хүснэгт 17. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, жил бүрийн эхний VI сард

Үзүүлэлт		2018 I-VI	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд		224	169	162	109
1 Хүн амины	Санаатай	2	1	3	6
	Учрал	2	4	1	3
Хүчин		2	1	1	3
Дээрэм		5	1	1	1
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх		3	3	3	16
Хулгай	Иргэдийн өмчийн	80	50	32	6
	Малын	7	8	10	-
	Халаасны хулгай	1	-	1	1
	Аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн	-	-	-	-
	Автомашины	1	1	2	-
Залилан		8	13	23	8
Бусдын бие махбодид гэмтэл учруулсан		75	60	69	45
Авто тээвэр		12	12	5	1
Бусад		23	15	11	16
Илрүүлээгүй гэмт хэргийн тоо		135	88	86	44
Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь		36.3	45.3	43.0	40.6
Гэмт хэрэгт холбогдогчид, бүгд		93	86	85	89
Үүнээс:	Ажилгүй	42	67	70	67
	Албан хаагч	10	2	1	1
	Сурагч	-	1	1	2
	Оюутан	5	-	3	-
	Малчин	-	1	-	-
	Төрийн бус байгууллагын ажилтан	5	3	2	2
	ХХЭ болон хувийн хэвшилд ажиллагч	31	12	5	17
Эрүүлжүүлэгдсэн хүн		1 537	1 586	2 198	1 133
Үүнээс: Эмэгтэй		-	168	76	124

Зураг 4. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороодоор



Гэмт хэргийн улмаас 9 хүн нас барж, 45 хүн гэмтэж бэртсэн бөгөөд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нийтдээ 145.3 сая төгрөгийн хохирол учруулсны 97.5 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна.

2021 оны эхний 6 сард 11991 зөрчил илрүүлж, 858 иргэн, 2 хуулийн этгээдийг 135.2 сая төгрөгөөр торгож, 1133 (эмэгтэй 124) иргэнийг эрүүлжүүлж, 205 иргэний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 53 иргэнийг шүүхийн шийдвэрээр баривчлуулжээ.

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтэс



ТӨСӨВ

2021 оны эхний 6 сард дүүргийн төсөвт 1506.1 сая төгрөгийн татварын орлого төвлөрч, төлөвлөгөө 95.1 сая төгрөгөөр (6.7%) давж биелсэн байна.

Зураг 5. Орон нутгийн татварын орлого бүрдэлт, сая төгрөгөөр



Эх үүсвэр: Татварын хэлтэс



ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ

Түүхий эдийн үнэ өмнөх оны мөн үеэс тэмээний шир 5000 төгрөгөөр (25%), адууны шир 2000 (20%) өсч, үхрийн шир 10000 төгрөгөөр (66.6%) буурч, ямааны ноолуургүй арьс 500 (50.0%) буурсан байна.

Хүснэгт 18. Зарим түүхий эдийн үнэ, жил бүрийн VI сард



Түүхий эдийн нэр	Хэмжих нэгж	2018 VI	2019 VI	2020 VI	2021 VI
		Төгрөг			
Тэмээний шир	ширхэг	10 000	10 000	20 000	25 000
Адууны шир	ширхэг	10 000	11 000	10 000	12 000
Адууны дэл	кг	-	5 500	5 000	10 000
Адууны сүүл	кг	-	10 000	10 000	13 000
Үхрийн шир (дундаж үнэ)	1.8-2.3 метр хэмжээтэй ширхэг	25 000	20 000	15 000	5 000
Хонины арьс	ширхэг	2 000	-	2 500	500
Ямааны арьс (ноолуургүй)	ширхэг	1 000	1 000	1 000	500
Ямааны ноолуур	кг	85 000	-	45 000	100 000

Хүснэгт 19. Нэг литр шатахууны үнэ, төгрөг

ШТС	2020.VI.26					2021.VI.30				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	-	1 260	1 320	1 790	-	-	1 350	1 450	2 150	-
Петровис	1 800	1 350	1 400	1 890	-	2 250	1 400	1 450	2 290	-
Магнай трейд	1 800	-	1 400	1 890	-	2 250	-	1 450	2 290	-
Сод монгол	1 800	-	1 400	1 890	-	2 250	-	1 450	2 290	-
Шунхлай	1 800	-	1 400	1 890	-	2 250	-	1 450	2 290	-
Юнигаз	-	-	-	-	970	-	-	-	-	1 130
Дундаж үнэ	1 800	1 405	1 384	1 870	970	2 250	1 375	1 450	2 262	1 130

Эх үүсвэр: Нийслэлийн статистикийн газрын 7 хоногийн үнийн судалгааны дүн

Зураг 6. Нэг литр шатахууны дундаж үнэ 2021 оны VI сард



АЖ ҮЙЛДВЭР

2021 оны эхний 6 сарын аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад цахилгаан эрчим хүч 31.7 хувиар дулаан хангамж 2.5 хувиар өсч, усан хангамж 8.6 хувиар буурсан байна.

Олборлох үйлдвэрийн хувьд элс 3 дахин, шохойн чулуу 32.3 хувиар өсч, хайрга 2.5 хувиар буурсан байна.

Боловсруулах үйлдвэрийн хувьд тоосго 37.2 хувиар буурч, цемент 15.2 хувиар өсч, оёдол 33.3 хувиар, хэвлэлийн будаг 54.6 хувиар тус тус буурсан байна. Замаска 64.7 хувиар, барилгын шавардлагын хар замаска 1.6 хувиар, плитаны цавуу 41.6 хувиар тус тус буурсан байна. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрийн хувьд талх 3.3 хувиар буурч, нарийн боовны үйлдвэрлэлт 32.0 хувиар, савласан цэвэр усны үйлдвэрлэл 20 дахин өссөн байна. Харин мах боловсруулж бэлтгэхэд үхрийн мах 95.4 хувь, хонины мах 3 дахин, ямааны мах 14 дахин, адууны мах 14 дахин, утсан чанасан болон хагас боловсруулсан мах 6 дахин өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад цахилгаан эрчим хүч 32.7 хувиар, усан хангамж 4 дахин өссөн байна. Дулаан хангамж 2.4 хувиар буурсан байна. Олборлох үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалтын хувьд шохойн чулуу 50.3 хувиар өссөн, хайрга 3 дахин буурсан, элс 2.5 дахин өссөн байна.

Боловсруулах үйлдвэрийн борлуулалтын хувьд тоосго, оёдол, арьсан цүнх, түрийвч, арьсан эдлэл, гэр ахуйн оёмол эдлэл, хэвлэлийн будаг, замаска, хар замаска, плитаны цавуу, хэвлэлийн хор 5.9-68.8 хувиар тус тус буурсан байна. Цемент 33.6 хувь өссөн байна.

Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэр борлуулалтын хувьд 43.5 хувиас 20 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 20. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, жил бүрийн эхний VI сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Нийт үйлдвэрлэлт					
		Биет хэмжээгээр			Үнийн дүнгээр, сая / төг		
		2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI
Эрчим хүчний үйлдвэр:							
Цахилгаан	сая.квт.цаг	76.7	57.4	75.6	12.6	10.7	14.2
Дулаан	мянган.гкал	50.3	48.5	49.7	2 142.4	2 257.2	2 203.6
Усан хангамж	мянган м³	919.8	758.2	692.5	265.0	231.5	920.1
Олборлох үйлдвэр:							
Шохойн чулуу	тонн	14.3	13.6	18.0	123.0	135.7	204.0
Нүүрс	мянган тонн	-	-	-	-	-	-
Хайрга	мянган м³	3.5	5.1	2.6	51.9	82.8	24.2
Дайрга	мянган м³	0.44	1.6	-	2.4	11.5	-
Элс	мянган м³	14.7	14.1	44.4	122.4	126.2	324.2
Боловсруулах үйлдвэр:							
Тоосго	мян/ширхэг	5 133.0	1 959.0	1 230.2	1 449.3	515.9	290.2
Цемент	мянган тонн	11.39	9.9	11.4	1 655.7	1 264.3	1 688.6
Бетон зуурмаг	мянган м³	-	-	5.1	-	-	851.0
Оёдол	мян/ширхэг	13.5	0.3	0.2	740.7	6.3	10.3
Аюултай хог хаягдал булах	тонн	-	-	730.8	-	-	785.6
Аюулгүй хог хаягдал зайлуулах	мян/тонн	-	-	13 843.4	-	-	129.4
Арьсан цүнх, түрийвч эдлэл	мян/ширхэг	39.9	33.0	-	232.1	50.3	-
Берзинтэн цүнх	мян/ширхэг	-	6.8	0.9	-	115.6	7.0
Замаска	тонн	31.0	69.5	24.5	7.7	18.0	5.6
Барилгын шавардлагын хар замаска	тонн	60.0	78.0	76.7	18.0	23.4	22.0
Плитаны цавуу	тонн	30.0	55.3	32.3	10.0	18.8	10.1
Эрдэст нунтаг	тонн	-	1 495.2	1 486.6	-	68.0	81.7
Хэвлэлийн хор	мян/ширхэг	11.0	6.4	2.9	241.1	171.9	146.4
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл:							
Талх	тонн	25.53	15.3	14.8	51.6	30.7	18.6
Нарийн боов, жигнэмэг	тонн	23.94	10.6	14.0	45.4	20.0	28.7
Утсан чанасан болон хагас боловсруулсан мах	тонн	85.2	250	2573	622.3	1 785.5	21 121.3
Үхрийн мах	тонн	-	105	205.2	-	787.5	1 566.7
Хонины мах	тонн	-	59.3	187.3	-	383.5	1 279.5
Ямааны мах	тонн	-	42.1	601.4	-	252.6	4 626.7
Адууны мах	тонн	-	100	1 453.3	-	6 190.0	9 194.2
Өлөн гэдэс	мян/гогцоо	62.2	-	57.7	1 119.6	-	1 372.3
Элэгний нухаш	тонн	0.9	-	2.8	4.5	-	15.4
Цэвэр ус	мянган литр	2 360	316.8	7 035.0	505.1	61.5	741.2

Эх үүсвэр: Дүүргийн аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа тогтмол явуулсан ААН-ын дүнгээр



МАЛ АЖ АХУЙ


2021 оны эхний 6 сард 17133 хээлтэгч малаас 17133 төл гарснаас 841 төл мал хорогдож, 16292 төл бойжиж, төл бойжилт 95.1 хувьтай байна. Бойжсон төлийн 7.7 хувийг унага, 17.5 хувийг тугал, 45.0 хувийг хурга, 29.8 хувийг ишиг эзэлж байна.

Хүснэгт 21. Мал төллөлт, том малын хорогдол, малын төрлөөр

Үзүүлэлт / төрөл	2020 I-VI	2021 I-VI	Үүнээс:				
	Бүгд		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Төллөсөн хээлтэгч	18 433	17 133	2	1 298	2 940	7 787	5 106
Гарсан төл	18 439	17 133	2	1 298	2 940	7 787	5 106
Хорогдсон төл	693	841	-	50	88	451	252
Бойжсон төл	17 746	16 292	2	1 248	2 852	7 336	4 854
Бойжилтын хувь	96.2	95.1	100	96.1	97.0	94.2	95.0
Хорогдсон том мал	981	1 769	-	152	438	674	505
Хорогдсон хээлтэгч	572	777	-	48	184	303	242


Эх үүсвэр: Хороодын сар бүрийн мал төллөлт, хорогдлын мэдээний нэгдсэн дүн

Зураг 7. Том малын зүй бусын хорогдол, гарсан төл хороодоор



Эхний 6 сарын байдлаар том малын зүй бус хорогдол нийт 1769 бүртгэгдсэнээс 3-р хороонд 563 (31.8%) буюу хамгийн их, 8-р хороонд хамгийн бага буюу 18 (1.0%) малын хорогдол бүртгэгдсэн байна.

Малын төрлөөр авч үзвэл хонь хамгийн их буюу 451 (53.6%) хорогдож, хамгийн бага 50 (5.9%) буюу адуу хорогдсон байна.



ГАЗАР ТАРИАЛАН

2021 оны эхний хагас жилийн байдлаар 6.16329 га талбайд төмс хүнсний ногоо тариалсныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 18.8 хувиар буурсан ба нийт талбайн 77.7% -д төмс тарьсан байна.

Хүснэгт 22. Төмс, хүнсний ногооны тариалалт жил бүрийн эхний VI сард (га):

Нэр төрөл/он	2017	2018	2019	2020	2021
Төмс	25.4	8.57	7.96	4.2603	4.79015
Хүнсний ногоо	17.34	8.1708	4.05	3.33151	1.37314
Үүнээс:					
Байцаа	4.021	1.9502	0.84	0.1764	0.1554
Манжин	3.299	2.1069	0.35	0.1841	0.12593
Улаан манжин	1.572	0.5781	0.11	0.1107	0.08323
Лууван	2.51	1.926	1.12	0.2637	0.13278
Сонгино	1.25	0.5938	0.05	0.8492	0.1201
Сармис	0.42	0.0143	0.03	0.073	0.0118
Өргөст хэмх	1.86	0.2155	0.27	0.3654	0.2076
Өргөст хэмх /давжаа/	-	-	-	0.02	0.0378
Улаан лооль	0.84	0.4294	0.25	0.4882	0.1941
Чинжүү	0.11	0.1067	0.04	0.1122	0.049
Тарвас	0.02	0.0008	0.15	0.02	0.0044
Хулуу	-	0.0014	0.004	0.0087	0.0074
Амтат гуа	-	-	0.003	0.008	0.0022
Цэцэгт байцаа	-	-	-	0.0104	0.0129
Брокколи	-	-	-	0,0315	0.0026
Салатны навч /шанцай/	-	-	-	0.02851	0.0253
Бууцай	-	-	-	0.031	0.0064
Хаш	-	-	-	0,001	0.0025
Амтлагч ногоо	-	-	-	-	0.0006
Бусад	1.406	0.2477	0.94	0.5495	0.1911
Бүгд	42.74	16.74	12.01	7.59181	6.16329

Зураг 8. 2017-2021 оны төмс, хүнсний ногоо тариалалт /га/



Эх үүсвэр: 8 хорооны статистик мэдээ



МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа холбооны байгууллага 138.7 сая төгрөгийн орлоготой ажиллаж, үүнээс 67.9 сая төгрөг (48.9%) нь хүн амд үзүүлсэн үйлчилгээний орлого эзэлж байна.

Телефон цэгийн тоо өмнөх оны мөн үеэс 73 (10.0%) өссөн байна. Нийт суурин телефон цэгийн 512 (63.8%) нь айл өрхийн эзэмшилд байгаа бол 195 (24.3%) нь төсвийн байгууллагад, 95 (11.9%) нь бизнесийн байгууллагуудад ашиглагдаж байна.

Хүснэгт 23. Харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний VI сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I-VI	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI
Нийт орлого	сая төгрөг	117.9	126.4	141.1	138.7
Үүнээс: хүн амд үзүүлсэн үйлчилгээний	сая төгрөг	57.8	61.9	69.1	67.9
Телефон цэг	тоо	594	622	729	802
Үүнээс: айл өрх	тоо	335	352	457	512
Интернет үйлчилгээний цэг	тоо	2	2	2	2
Интернет үйлчилгээний суудал	тоо	20	20	20	17
Интернет үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчид	тоо	2 619	2 119	625	375
Интернетийн байнгын хэрэглэгчид	тоо	393	530	140	410
Таксофон	тоо	1	1	1	1

Эх үүсвэр: Налайх дүүргийн холбооны газар

Хүснэгт 24. Кабелийн телевизийн үзүүлэлт, жил бүрийн эхний VI сард

Үзүүлэлт / он	хэмжих нэгж	2018 I - VI	2019 I - VI	2020 I-VI	2021 I-VI
КТВ-ийн орлого	мян.төг	80 000.0	34 531.7	28 447.9	33 796.0
Хэрэглэгч	тоо	3 575	3 650	1 100	1 258



АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Дүүргийн Онцгой байдлын хэлтэс 2021 оны эхний 6 сард гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж 120 аж ахуйн нэгж, байгууллагад 387 зөрчил илрүүлэн, 279 зөрчлийг арилгуулан, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 33, мэдэгдэл 43, зөрчлийн тэмдэглэл 12, дүгнэлт 9, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 28

хүргүүлсэн байна. Мөн объектын гал түймрийн 21 дуудлагаар ажиллаж, 271.0 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

Хүснэгт 25. Гал түймрийн дуудлагын тоо, жил бүрийн эхний VI сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I-VI	2019-I-VI	2020 I-VI	2021 I-VI
Бүгд		48	36	29	21
Өмчийн хэлбэрээр:					
Төрийн өмч	тоо	5	2	-	-
Хувийн өмч	тоо	42	32	28	20
Аж ахуйн нэгж	тоо	1	2	1	1
Гал түймэрт өртөж шатсан:					
Нас барсан	хүүхэд	1	-	-	-
	том хүн	2	-	-	2
Түлэгдэж бэртсэн	хүүхэд	-	-	-	-
	том хүн	1	-	-	-
Өвөл зуны сууц	тоо	10	4	12	6
Гэр	тоо	8	1	4	6
Нийтийн орон сууц	тоо	-	-	2	-
Хог, хогийн суваг	тоо	13	8	4	4
Машин техник	тоо	3	3	6	1
Барилга байгууламж	тоо	2	3	1	1
Малын хашаа саравч	тоо	1	3	-	-
Шалтгаан:					
Цахилгааны	тоо	2	1	4	4
Ил задгай асгасан үнс, нурмаас	тоо	-	4	6	6
Лаа, тамхи, шүдэнз	тоо	14	3	1	1
Пийшин зуухны цонолт	тоо	-	-	1	1
Машин техник гэмтэл, буруу ашигласан	тоо	1	-	3	-
Гагнуур паялник бамбараас	тоо	-	-	1	1
Архидан согтуурснаас	тоо	1	-	2	2
Бусад	Тоо	-	-	1	1
Шалтгаан тогтоогдоогүй	Тоо	30	28	10	5
Аварсан эд хөрөнгө:					
Хүн	тоо	1	-	4	4
Өвөл зуны сууц	тоо	4	4	6	4
Гэр	тоо	3	1	3	1
Барилга байгууламж	тоо	3	1	1	1
Машин техник	тоо	2	1	4	1
Улсын онц чухал болон галын онц аюултай объект	тоо	1	-	-	-
Эд хөрөнгө	сая төгрөг	247.0	200.6	564.0	271.0

Эх үүсвэр: Онцгой байдлын хэлтэс

Хүснэгт 26. Газартай холбоотой асуудал шийдвэрлэлт, 2021 оны эхний VI сард

2021 оны эхний 6 сард дүүргийн Засаг даргын 19 удаагийн захирамжаар нийт 442 иргэн, 44 аж ахуйн нэгж байгууллагын газартай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн байна.

Зориулалт	Газрын хэмжээг өөрчлөх	Газар эзэмших эрхийг хүчингүй болгох	Газар эзэмших эрх олгох, баталгаажуулах	Газар эзэмших эрхийг шилжүүлэх	Газар өмчлөх	Хамтран өмчлөгч хасуулах	Газрын байршил өөрчлөх	Газар ашиглуулах эрх олгох
Иргэн, ААНБ-ын тоо	9	9	103	336	-	-	16	13

Эх үүсвэр: Газар зохион байгуулалтын алба

ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШИЙДВЭРЛЭЛТ

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэх, хариу өгөх, хяналт тавих, тайлагнах ажлыг “Өргөдөл, гомдлын нэгдсэн программ”-аар явуулж байгаагийн зэрэгцээ “Налайх сонсож байна” 7023-2727, 1800-1200 тусгай дугаарын утас, Засгийн газрын 11-11 утас, www.ubl200.mn цахим хуудас, Check my service аппликейшн зэргээр иргэдийн гомдол, хүсэлт, саналыг хүлээн авч байна.

2021 оны эхний 6 сард дүүргийн Засаг даргын Тамгын газарт нийт 519 санал, хүсэлт, өргөдөл хүлээн авсан байна. Эдгээрээс 498 санал, хүсэлт, өргөдөлд хариу өгч, шийдвэрлэх шатандаа явагдаж байгаа 21, хугацаа хэтэрсэн 0 санал хүсэлт байна. Санал хүсэлтийн шийдвэрлэлт 95.0 хувьтай. Ирсэн өргөдөл, гомдол, саналын 459 (88.4%) нь бичгээр, 60 (11.6%) нь тусгай дугаар болон гар утасны аппликейшн үйлчилгээгээр хандсан байна.

Эх үүсвэр: ЗДТГ-ын нэг цонхны үйлчилгээ

Танилцуулгыг татаж авах линк :

www.ubstat.mn

Налайх дүүргийн Статистикийн
хэлтэс facebook page

Утас: 7023-3672

УБ хот, Налайх дүүрэг ЗДТГ-ын байр 2 давхар 210 тоот